

## МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар хот

### Арга хэмжээ авч ажиллах тухай

Монгол Улсын шадар сайдын 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 87 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхтэй холбогдуулан ДААЛГАХ НЬ:

1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаад мэргэжилтэн, инженер техникийн ажилчид, тэр дундаа Бүгд Найрамдах Энэтхэг Улсын инженер, мэргэжилтнүүдийг татан авах захиалгат болон тусгай үүргийн нислэгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч шуурхай зохион байгуулж ажиллахыг Улсын онцгой комисст;

2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцож буй гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдыг үйлдвэрийн болон хотхоны талбай руу зорчих, нэвтрэх асуудлыг хорио цээрийн хялбаршуулсан горимоор зохицуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Дорноговь аймгийн онцгой комисст;

3. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажлын үед болон зарим дэд бүтцийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах хүрээнд Ширээт дэд станцыг 110/35/10 кВ 25 МВт-аар өргөтгөх, газрын тос дамжуулах хоолойн толгой насос станц болон эхний өргөх станцад шаардлагатай 4 МВт хүртэлх цахилгаан эрчим хүчийг Чойбалсан-Тосон-Уул XIX талбайн 110кВ Цахилгаан дамжуулах агаарын шугамаас хангах, дамжуулах хоолойн завсрын өргөх 2-3 станцад шаардлагатай 4 МВт хүртэлх цахилгаан эрчим хүчийг Чойбалсан- Баруун-Уртын 110кВ Цахилгаан дамжуулах агаарын шугамаас хангах асуудлыг тус тус судалж шийдвэрлэх, Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Ширээт дэд станцын арчилгаа, хамгаалалт, ашиглалт, ажиллагааны бэлэн байдлыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанид хариуцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд;

4. Газрын тос боловсруулах үйлдвэрт олгож буй Хөгжлийн банкны зээлийн хүүг бууруулах, зээлийн хугацааг сунгах, тус зээлийг гадаадын банк, санхүүгийн байгууллагын бага хүүтэй санхүүжилт болон бусад хямд эх үүсвэрээр хаах боломж, нөхцөлийг судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул нарт;

5. Хөгжлийг банк болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны зардал болон үйлдвэрийн хотхоны барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүр түргэн шуурхай олгож ажиллахыг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуулд;

6. Түүхий тос дамжуулах хоолойн санхүүжилтийн эргэн төлөлтөд Монгол улсын Засгийн газрын баталгаа гаргах асуудлыг яаралтай судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

7. Сайншандаас Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 17 км хүнд даацын авто замын арчлалт, ашиглалтын бэлэн байдлыг хангахтай ажлыг хариуцах, холбогдох зардлыг Зам тээврийн хөгжлийн яамны авто зам арчлалтын төсөвт тусгах, тус замыг зүүн чиглэлийн авто замын төлөвлөлтөд хамруулж, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт үе шаттайгаар суулгаж, өндөр хүүтэй Хөгжлийн банкны зээлийг эргэн төлөх боломжийг тус тус судалж танилцуулах, Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажилд зориулан импортлох техник, тоног төхөөрөмж, бараа материалыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин, Эрээн боомтоос татан авах, Замын Үүдийн боомтоор дараалал харгалзахгүйгээр шуурхай нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, Оросын Холбооны Улсын боомтоор оруулж ирэх боломж, өртөг зардлыг судалж танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Халтарт;


8. Дотоодын их, дээд сургуулиудад Газрын тос боловсруулах үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажилчид, мэргэжсэн мэргэжилтэн, хүний нөөц буюу “Газрын тосны доош урсгалын инженерүүдийг бэлтгэх” тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх санал боловсруулах, сургалтын төлбөрийг Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудын сургалтын урамшууллаас санхүүжүүлэх талаар холбогдох журмын төсөл боловсруулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;

9. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас олон улсын тээвэр, бараа материалын үнэ өсч, татан авалт, хүн хүчний асуудалд их хэмжээний хүндрэл учирч байгаа тул үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд хэвийн явуулахын тулд Монгол улстай ойр, эсвэл хил залгаа улс орнуудаас бараа, ажил, үйлчилгээг авах ажлыг зохион байгуулах шаардлагатай тулгарч байгаатай холбогдуулан Энэтхэгийн талаас экспортлох эрх бүхий бараа, үйлчилгээний үнийн дүнгийн хэмжээг 50 хүртэл бууруулах асуудлаар Бүгд Найрамдах Улсын Энэтхэг Улсын Гадаад хэргийн яам болон Экспорт-Импортын банкттай хэлэлцээр хийж, шийдвэрлэх чиглэлээр ажиллахыг Гадаад хэргийн сайд Б.Батцэцэгт;

10. Газрын тос дамжуулах хоолойн трассын дагуух зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, гэрчилгээжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;

11. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зориулалтаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгосон газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайд явуулах хайгуулын үйл ажиллагааг дэмжих хүрээнд хайгуулын өрөм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөц, чадавх бүхий мэргэжлийн анги, баг бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалт, арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН